



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/189

Алтай хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 11.3.2 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргын хамтран ажиглах гэрээний 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд, төрийн байгууллагууд, хуулийн этгээдийг 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 09:00 цагаас 04 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цаг хүртэл хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд аймгийн хэмжээнд төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд ажлын тусгай горим уртасгасан цагаар ажиглаж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, команд штабын сургуулийн бэлтгэлийг хангаж оролцохыг үүрэг болгосугай.

3.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн удирдлага, зохион байгуулалт, ажиллагаанд оролцож буй бусад байгууллагуудын ажлын уялдааг хангаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц)-т даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ